



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 07 сарын 08 өдөр

Дугаар 360

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 4 дэх заалт, Говь-Алтай аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны 15 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Говь-Алтай аймгийн өмчөөс шилжүүлсэн нийт 2,685,622,030.00 (хоёр тэрбум зургаан зуун наян таван сая зургаан зуун хорин хоёр мянга гуч) төгрөгийн балансын үнэ, 137,612,429.75 (нэг зуун гучин долоон сая зургаан зуун арван хоёр мянга дөрвөн зуун хорин есөн төгрөг далан таван мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг төрийн өмчид хүлээн авч “Алтай-Улиастайн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. “Алтай-Улиастайн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Б.Цэдэвсүрэн, Говь-Алтай аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Л.Ганхуяг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалтын цахим систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

122331636
16-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн
 дугаар тогтолцоульян хавсралт
 "АЛТАЙ-УЛИАСТАЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХӨРӨНГӨД БҮРТГЭХ
 ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Хөрөнгө

Д/д Хөрөнгийн нэр
Цахилгааны хаалттай дэд өртөө

Хөрөнгө

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалта д. орсон огноо	Тоо хэмжээ х нэгж	Хэмжи х нэгж	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын үнэ (төгрөг)	Хурийтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)
1	Цахилгааны хаалттай дэд өртөө	2021	5	Ш	222,919,759.00	1,114,598,795.00	24,149,640.56	1,090,449,154.44
2	Цахилгааны магистраль шугам	2021	7250	М	216,692.86	1,571,023,235.00	113,462,789.19	1,457,560,445.81

2,685,622,030.00
 (хоёр тэрбум
зургаан зуун наян
таван сая зургаан
зуун хорин хоёр
мянга гуч)

137,612,429.75

2,548,009,600.25

(хоёр тэрбум
зургаан зуун наян
долоон сая зургаан
зуун арван хоёр
мянга дөрвөн зуун
хорин есөн төгрөг
далан таван мөнгө)

Нийт дүн